



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.01.18 № 01/03

САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ТҮВШИНБААТАР ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сайхан-Овоо сумын тусгай зориулалтын сангуудад санхүүгийн аудит хийх явцад 121,185,669.00 /Нэг зуун хорин нэгэн сая нэг зуун наян таван мянга зургаан зуун жаран ес/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн байдлаар нийт 103,145,669.00 төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заасныг зөрчсөн байна.

2. Малчин өрхийг малжуулахаар олгосон 18,040,000.00 төгрөгийн зээлийн эргэн төлөлтөөр авсан малыг холбогдох журмын дагуу бүртгээгүй.

Энэ нь Засгийн газрын 2010 оны 197 дугаар тогтоолоор баталсан “2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам”-ын 25-д /Амьжиргааг дэмжих зөвлөл, малчны хооронд байгуулсан гэрээний биелэлтэд сум, багийн Засаг дарга хяналт тавин ажиглаж, мөнгөн төлбөрийг нь аймгийн “Мал хамгаалах сан”-гийн дансанд шилжүүлж, харин малаар нь өгөх төлбөрийг аймгийн “Мал хамгаалах сан”-д тухайн малын зах зээлийн үнээр бүртгэн авч, зохих журмын дагуу тухайн сумын малжуулах төсөлд хамрагдах дараагийн малчинтай гэрээ байгуулж болно/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй

0000000006

үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журамд зааснаас бусад зориулалтаар ашиглаж, зарцуулахгүй байх;
2. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
3. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бууруулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
4. Зээлийн эргэн төлөлтөөр авсан малыг тоо, толгойгоор дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, холбогдох тооцоог хийх;
5. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Засаг дарга Б.Түвшинбаатар, нягтлан бодогч З.Цэдэнрулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН ¹ :		ЗӨВШӨӨРСӨН:
ШИНЖЭЭЧ	Ж.УГТАХБАЯР	СУМЫН ЗАСАГ
		ДАРГА
		Б.ТҮВШИНБААТАР
		НЯГТЛАН БОДОГЧ
		З.ЦЭДЭНРУЛАМ

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/